



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Чулуут-Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2024/10-НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)  
Архангай аймаг  
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerguibaatard@audit.gov.mn](mailto:Nerguibaatard@audit.gov.mn)  
Аудитор Н.Дашмягмар  
Утас: 7033-3019  
Цахим хаяг: [Dashmyagmarn@audit.gov.mn](mailto:Dashmyagmarn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>5</b>
<b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....</b>	<b>5</b>
<b>2.2 Аудит хийсэн орлогын тайлан .....</b>	<b>5</b>
<b>2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....</b>	<b>6</b>
<b>2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....</b>	<b>7</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>3.2 Байгууллагын үйл ажиллагааны гадаад, дотоод орчин.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө ба гүйцэтгэл.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.1 Ерөнхий зүйл.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.2 Материаллаг байдал .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.4.1 .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4.5.1 Завсрын аудитын талаар .....</b>	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....</b>	<b>9</b>
<b>5.1 Албан шаардлага.....</b>	<b>9</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>9</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

ААНОАТ	Аж Ахуй Нэгжийн Орлогын Албан Татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.15 № 149

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ЧУЛУУТ-АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Ч.ЧИМЭДДЭЛЭГ  
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чулуут-Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Чулуут-Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. “Чулуут Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын 2023 оны орлого, зардлын тооцооллыг үндэслэлтэй тооцоогүй, аймгийн Засаг даргаар батлуулсан бизнес төлөвлөгөөнөөс зардлыг 22,074.7 мянган төгрөгөөр хэтрүүлж 24,053.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
2. Тус газрын захирал нь сумын Засаг даргатай гэрээ байгуулж ажиллаагүй, сумын Засаг даргаас үйл ажиллагаанд нь хяналт тавьж, үр дүнг үнэлээгүй байна.
3. Татварын байгууллагад хуулийн дагуу ногдуулсан 6298.7 мянган төгрөгийн албан татварыг төлж барагдуулаагүй, өр төлбөрийн үлдэгдэлтэй.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

“Чулуут-Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГазрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1.00</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.10</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	57,354.86	8,800.00
1.1.2	Дансны авлага	105,000	2,562,00.00
1.1.6	Бараа материал	2,132,745.00	3,527,200.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,295,099.86</b>	<b>6,098,000.00</b>
<b>1.20</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,108,488,332.66	1,085,347,096.66
1.2.9	Бусад үндсэн хөрөнгө	911,970.00	810,640.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,109,400,302.66</b>	<b>1,086,157,736.66</b>
<b>1.30</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,111,695,402.52</b>	<b>1,092,255,736.66</b>
<b>2.00</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.10</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>1,683,731.94</b>	<b>6,297,769.42</b>
2.1.1.1	Дансны өглөг	1,289,545.00	1,915,843.44
2.1.1.3	Татварын өглөг	394,186.94	1,521,306.55
2.1.1.5	НӨАТ-ын өглөг		2,860,619.33
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,683,731.94</b>	<b>6,297,769.42</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.20</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,683,731.94</b>	<b>6,297,769.42</b>
	<b>Эздийн өмч</b>		
<b>2.30</b>	<b>Өмч :</b>		
2.3.1	а) төрийн	1,261,748,800.00	1,261,748,800.00
2.3.2	б) хувийн		
2.3.3	в) хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	(19,240,890.00)	(19,240,890.00)
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(170,978,019.42)	(195,031,722.77)
2.3.10	Өмнөх үеийн ашиг (алдагдал)	(170,978,019.42)	(170,978,019.42)
2.3.11	Тайлант үеийн ашиг (алдагдал)		(24,053,703.53)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,110,011,670.58</b>	<b>1,085,957,967.23</b>
<b>2.40</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,111,695,402.52</b>	<b>1,092,255,736.66</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	-	-
4	Түрээсийн орлого	29,654,000.00	42,600,269.00
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Хандив тусламжийн орлого		20,000,000.00
8	Бусад орлого	5,524,900.00	25,158,249.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	58,822,494.11	111,812,221.35

“Чулуут-Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-аар 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

10	Ерөнхий ба удирдлагын зардал		
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(23,643,594.11)</b>	<b>(24,053,703.53)</b>
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(23,643,594.11)</b>	<b>(24,053,703.53)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(23,643,594.11)</b>	<b>(24,053,703.53)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(23,643,594.11)</b>	<b>(24,053,703.53)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Халаасны хувьцаа	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,261,748,800.00	19,240,890.00	(170,978,019.42)	1,110,011,670.58
3	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,261,748,800.00	19,240,890.00	(170,978,019.42)	1,110,011,670.58
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	<b>(24,053,703.53)</b>	<b>(24,053,703.53)</b>
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-		
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-		
7	Зарласан ногдол ашиг	-	-		
8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн	-	-		
9	<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	1,261,748,800.00	19,240,890.00	<b>(195,031,722.77)</b>	<b>1,085,957,967.23</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>38.609.570.00</b>	<b>90,033,407.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	<b>38.609.570.00</b>	44,403,296.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		20,000,000.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Үйл ажиллагааны орлого		25,630,111.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	240,000.00	
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>37,596,173.00</b>	<b>90,081,961.86</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	20,979,596.00	29,519,900.00

“Чулуут-Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГазрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,488,875.00	7,072,719.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,360,030.00	2,009,200.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,395,672.00	17,325,769.82
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		31,919,373.89
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	5,372,000.00	1,074,046.16
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага		1,160,953.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,013,397.00</b>	<b>(48,554.86)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,013,300.00</b>	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,013,300.00	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,013,300.00)</b>	
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсө		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>		
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>97.00</b>	<b>(48,554.86)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>57,354.86</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>57,354.86</b>	<b>8.800.00</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

/төгрөгөөр/

ДД	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Түрээсийн орлого	45,942,000.00	44,403,296.00	1,538,704.00	96,6%
2	Халуун усны орлого	5,400,000.00	4,149,381.00	1,250,619.00	76,8%
3	Хогны хураамжийн орлого	14,400,000.00	21,413,230.00	7,013,230.00	148,7%
4	Сэг зэм устгах орлого ОНХСан	-	20,000.000.00	-	100%
	<b>Нийт орлогын дүн</b>	<b>65,742,000.00</b>	<b>89,965,907.00</b>	<b>(24,223,907.00)</b>	<b>(36.8%)</b>

“Чулуут-Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГазрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

1	Үндсэн ба нэмэгдэл цалин, НДШ	38,661,250.00	36,592,619.00	2,068,631.00	94,6%
2	Цахилгаан өөрийн хэрэглээ	9,360,000.00	10,965,770.00	(1,605,770.00)	117.1%
3	Түлш, шатахуун, тээврийн зардал	10,923,000.00	18,862,572.68	1,279,247.00	77,8%
4	Засвар, үйлчилгээний зардал	1,258,500.00	1,465,200.00	(206,700.00)	116,4%
5	Цэвэр бохирын зардал	1,400,000.00	6,380,000.00	(4,980,000.00)	219 %
6	Тоног төхөөрөмж	1,200,000.00	1,200,000.00	-	100
7	Бусад зардал	600,000	14,271,300.00	(13,671,300.00)	257,8%
<b>Нийт зарлагын дүн</b>		<b>63,402,750.00</b>	<b>89,737,461,87</b>	<b>(26,334,711.87)</b>	<b>(41.5%)</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах 3 албан шаардлага, хүргүүлээ.

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант хугацаанд дансны өглөг 4,614.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 6,297.7 мянган төгрөгийн өр төлбөрийн тооцоотой байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 “Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Богино хугацаат өр төлбөрийг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах

5.1.2 “Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын захирал нь Сумын засаг даргатай гэрээ байгуулаагүй, сумын Засар даргаас үйл ажиллагаанд нь хяналт тавиагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг улирал бүр дүгнүүлэх арга хэмжээ авч ажиллах

5.1.3 Тус газрын 2023 оны бизнес төлөвлөгөөг бодит баримт, мэдээлэлд үндэслэхгүйгээр зөрүүтэй боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулсан байх бөгөөд баталсан төлөвлөгөөнөөс зардлыг 22074.7 мянган төгрөгөөр хэтрүүлж, 24053.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Бизнес төлөвлөгөөг бодит баримт мэдээлэлд үндэслэн үнэн зөв боловсруулж батлуулах, батлагдсан зардлыг хэтрүүлэхгүй, ашигтай ажиллах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Өр төлбөрийг	1	6,297.7			1	6,297.7							

**“Чулуут-Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГазрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан**

барагдуулах											
Сумын засаг даргатай гэрээ байгуулж ажиллаагүй	1	0			1	0					
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>6,297.7</b>			<b>2</b>	<b>6,297.7</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан	1	0.0					1	0.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0.0</b>					<b>1</b>	<b>0.0</b>

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

